



“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ХК

2026 оны 03 дугаар сарын 11

Багануур дүүрэг

Паркийг байгуулах нь Монгол Улсын Засгийн Газраас хэрэгжүүлж байгаа шинэ сэргэлтийн бодлогын аж үйлдвэржилтийн сэргэлтийг хэрэгжүүлэх, нийслэл хотын хүн амын төвлөрлийг сааруулах, орон нутгийн нийгэм эдийн засгийг дэмжих, шинээр 4500-5000 гаруй ажлын байр бий болгох, байгаль орчинд халгүй өндөр технологийн импортыг орлох, экспортын чиглэлтэй үйлдвэрлэлийг байгуулах онцгой үүрэгтэй юм.

Эдийн засгийн үзүүлэлт: БҮТП-ийг байгуулснаар 4500-5000 орчим шууд ажлын байр бий болно. Энэ нь шинээр байгуулах улсын зэрэглэлийн Багануур хотын хүн амын өсөлт, Нийгэм эдийн засгийн хөгжилд суурь бүтэц болохоос гадна Засгийн газрын шинэ сэргэлтийн бодлогын аж үйлдвэржилтийн сэргэлт болон бүсчилсэн хөгжлийн бодлогын бодит томоохон үр дүн болно.

Нийгмийн ач холбогдол: БҮТП-ийг байгуулснаар 4500-5000 орчим шууд ажлын байр бий болно. Энэ нь шинээр байгуулах улсын зэрэглэлийн Багануур хотын хүн амын өсөлт, Нийгэм эдийн засгийн хөгжилд суурь бүтэц болохоос гадна бүс орон нутгийн хог хаягдлын менежмент, байгаль орчинд халгүй өндөр технологийн үйлдвэрлэлүүд байгуулагдах, тусгай болон инженерийн техникийн мэргэжилтэй ажилчин бэлтгэх, хөгжүүлэх боломж бий болно.

Паркад нэгж үйлдвэр байгуулах ажлын хүрээнд дараах хөнгөн, хүнд, хүнсний үйлдвэрлэлийн бүсэд “Натур ларикс вүүд” ХХК-аас Зиг-заг хавтан, модны үртсэн блок, тавилгын үйлдвэрийн төсөл хэрэгжүүлж шинээр 25-30 ажлын байр, Багануур “Мах маркет” ХХК-аас Малын тэжээл бэлтгэх, муур нохойн хоол үйлдвэрлэх төсөл шинээр хэрэгжүүлж 20-30 ажлын байр, “Трее Треелинг ойл” ХХК-аас Хүрэн нүүрснээс синтетик газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн төслийг хэрэгжүүлж шинээр 40-50 ажлын байр, Номин сүү ХХК нь сүү сүүн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрийн төсөл хэрэгжүүлэхээр 2025 оны 12 дугаар сард санамж бичгийг байгуулан ажиллаж байна.

Мэдээлэл өгөх ажилтан:
Үйлдвэрлэл, технологийн хэлтсийн
дарга Б.Мөнгөнхуяг.
Утас: 88656964